



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ-ЫН ШИЙДВЭР САВ ГАЗРЫН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ

2006 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Дархан

Дугаар 73

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.3 дахь заалт, Байгаль орчны сайдын 187 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Тус аймгийн нутаг дэвсгэрийн усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, төрөөс усны талаар баримталж буй бодлого, үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийг хангахад нутгийн иргэдийг татан оролцуулах зорилгоор гол, мөрний сав газрын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга- Д.Хаянхярваа Аймгийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга- Б.Лхасүрэн Байгаль орчны албаны дарга

Гишүүд- Г.Эрдэнэбат - ҮДББОБЗХэлтсийн дарга

3.Нэргүй- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Т.Буянбат- Мэргэжлийн хяналтын газрын дарга

Б.Энхжаргал -УЦУОШТөвийн дарга

С.Ганзориг- БОА-ны усны асуудал хариуцсан



мэргэжилтэн

Ч.Цэндсүрэн - Дархан сумын Засаг дарга

Д.Баяннамсрай- Шарын гол сумын Засаг дарга

Б.Батнаран- Хонгор сумын Засаг дарга

Б.Батбаяр- Орхон сумын Засаг дарга

Ж.Мижиддорж- УГТСЭШХүрээлэнгийн захирал

С.Элбэгбаян - “Дархан Ус суваг” ХК-ны захирал

Ш.Баранчулуун- ТИС-ийн салбарын дэд профессор

2.Аймгийн усны сав газрын зөвлөлийн ажиллах журмыг баталж, аймгийн нутаг дэвсгэр дэх усны тоо бүртгэл явуулж, усны мэдээллийн сан бүрдүүлэх, усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, ус усан орчинг нөхөн сэргээх асуудлуудыг

удирдан зохион байгуулах, хяналт тавих арга хэмжээг жил жилээр төлөвлөн хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Хаянхярваа/-д даалгасугай.

ДАРГА Л.ГҮНЧИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ